

Гарчиг

	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний тухай.....	2
	Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний гол зорилт, хамрах хүрээ.....	3
	Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө.....	3
БҮЛЭГ 1.	ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	4
1.1	Төсөл хэрэгжүүлэгч.....	4
1.2	Төслийн нэр.....	4
1.3	Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг.....	4
1.4	Төсөл хэрэгжих талбайн байршил, физик газарзүйн нөхцөл	4
1.5	Уурхайн жилийн хүчин чадал.....	5
1.5.1	Уулын ажлын горим:.....	5
1.5.2	Уулын ажлын төлөвлөлт	5
1.5.3	Шимт хөрс хуулах:	6
1.5.4	Уурхайн нээлт, ашиглалтын систем	7
1.6	“Цахилгаан хангамж.....	7
1.7	Усан хангамж.....	8
1.8	Туслах материал	9
1.8.1	Тэсэлгээний бодис.	9
1.8.2	Шатах тослох материал.....	10
1.8.3	Цацраг идэвхит бодис.	10
1.9	Хог хаягдал.....	10
1.10	Уурхайн тээвэр	12
1.10.1	Уурхайн дотоод зам:.....	12
1.10.2	Нүүрсний гадаад тээврийн зам:.....	12
БҮЛЭГ 2	БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДЛЫН ҮЗҮҮЛЭЛТ.....	13
2.1	Физик газарзүй:	13
2.2	Усан сүлжээ.....	14
2.3	Хөрс	14
2.4	Ургамалан бүрхэвч.....	14
2.5	Нийгэм эдийн засаг.....	15
2.6	Ордын судлагдсан байдал.....	15
2.7	Геоморфологи	16
2.8	Гидрогеологи.....	16
	БҮЛЭГ.3 ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГУЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	18
БҮЛЭГ. 4 БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ		21
	А. Байгаль хамгаалах төлөвлөгөө.....	22
	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	23
	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө.....	27
	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....	27
	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	27
	Түүх соёлын дурсгалт зүйлсийн менежментийн төлөвлөгөө	28
	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө.....	28

Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	29
Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө.....	31
Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь	31
Б.Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....	32
Хүснэгтийн жагсаалт	
Хүснэгт 1 Тусгай зөвшөөрөлтэй талбайн солбицлууд.....	4
Хүснэгт 2 2021 оны календарчилсан төлөвлөгөө.....	5
Хүснэгт 3 Бульдозерын бүтээл.....	6
Хүснэгт 4 Ил уурхайн технологийн агуулга, бүрдэл.....	7
Хүснэгт 5 Цахилгаан хэрэглэгчдийн суурь болон тооцооны актив чадал.....	7
Хүснэгт 6 Төслийн цахилгаан хэрэглээ	7
Хүснэгт 7 Усны хэрэглээ	8
Хүснэгт 8 Замын усалгаа	9
Хүснэгт 9 Төслийн нийт цэвэр усны хэрэглээ.....	9
Хүснэгт 10 Ашиглалтын жилүүд дэх тэсэлгээний хэрэгслийн тооцоо.....	9
Хүснэгт 11 Хог хаягдлын эх үүсвэрүүд.....	10
Хүснэгт 12 Улиралд гарах тосны хаягдал.....	11
Хүснэгт 13 Төслөөс байгаль орчинд нөлөөлж болзошгүй сөрөг нөлөөллийн матриц.....	18
Хүснэгт 14 Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл.....	19
Хүснэгт 15 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	23
Хүснэгт 16 Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ, зардал.....	27
Хүснэгт 17 Болзошгүй аюул осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөөний төсөв.....	28
Хүснэгт 18 “Өндөр жавхлант” хүрэн нүүрсний ордыг ашиглах төслийн хүрээнд гарах хог хаягдлын ангилал, устгах арга зам	30
Хүснэгт 19 Байгаль орчны менежментийн төлөвлөгөө.....	31
Хүснэгт 20 БОМТ-г танилцуулах, хэрэгжилтийг тайлагнах хуваарь.....	32
Хүснэгт 21 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....	33
Хүснэгт 22 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нэгдсэн төсөв.....	36
Зургийн жагсаалт	
Зураг 1 “Өндөр жавхлант” нүүрсний ордын байршил.....	5
Зураг 2 Гадаад тээврийн маршрут.....	13
Зураг 3 Өндөр жавхлантийн ордын тектоник хагарлаар хэрчигдсэн байдал.....	18

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний тухай

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний гол зорилт, хамрах хүрээ

Үйл ажиллагаа явуулахдаа байгаль орчинд учрах сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах, нөхөн сэргээх замаар байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа явуулах асуудлыг шийдвэрлэхэд чиглэгдэнэ. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлж ажилласнаар доорх зорилтуудыг ханган. Үүнд:

- БОМТ-нд тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбогдуулан ажилчдын үүрэг хариуцлагыг тогтоосон удирдлагын шатлал дараалал бий болсон байна.
- Ажилчдад нэг бүр байгаль орчныг хамгаалах асуудалтай холбоотой үүрэг хариуцлагаа бүрэн ойлгосон байхын зэргэцээ тэдэнд үүргээ биелүүлэхэд нь туслах бэлтгэл сургалтанд хамрагдсан ур чадвартай мэргэжилтэнтэй болсон.
- Байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл, эрсдэлийг урьдчилсан тооцооноор байгальд шууд болон шууд бус хэлбэрээр үзүүлэх нөлөөллийг бууруулах, байгаль орчны төлөв байдлыг сайжруулах, хэвийн хадгалж хамгаалах,
- Байгаль орчин хамгаалах сөрөг нөлөөллийг багасгах талаар ажилчдад зааварчилгаа өгч гарын авлага материалаар хангах,
- Байгаль орчны менежментийн асуудлаар БОННУ-ийн тайланд тусгагдсан зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх зэрэг болно.

“Өндөр жавхланта” нүүрсний ордыг ашиглах” төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг БОАЖ-ын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ийн өдрийн А/168 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ийн дагуу хийж гүйцэтгэлээ.

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 31-р зүйл болон 2012 онд шинэчлэн батлагдсан Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд аливаа төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний бүрдэл хэсэг болох байгаль орчинг хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоогдсон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, дүйцүүлэн хамгаалал хийх, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардалыг тусгасан байхаар заасан.

Хуулийн дээрх шаардлагын дагуу Хүүрэн нүүрсний ордыг ашиглах төслийн үйл ажиллагаанаас тухайн нутаг дэвсгэр, бүс нутгийн байгаль орчинд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүдийг бууруулах арга хэмжээ, шаардагдах хөрөнгө зардалыг хамт тодорхойлж, баримтлах хууль, дүрэм журам, стандартуудыг хамтатган байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг боловсруулав.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг заасан хугацаанд гаргаж төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэрийн захиргаа, ойр орчмын нутаг дэвсгэр дэх иргэдэд танилцуулах, тэдний саналыг нэгтгэн тусгах ажлыг зохион байгуулах, оролцогч болон сонирхогч талуудад мэдээллийг ил тод байлгах арга хэмжээг авсан байх шаардлагатай.

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1 Төсөл хэрэгжүүлэгч: “Мига эрин зуун” ХХК

1.2 Төслийн нэр: “Өндөр жавхланта” нүүрсний ордыг ил аргаар ашиглах

1.3 Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг 18-р хороо


Бэлхийн 42, 11 тоот Утас: +(976-11) 93161919 Email: dushiingol@gmail.com

1.4 Төсөл хэрэгжих талбайн байршил, физик газарзүйн нөхцөл:

Өндөр жавхланта нүүрсний орд нь Дорноговь аймгийн Сайхандулаан сумын нутагт орших ба Улаанбаатар хотоос 500 км, төмөр замын Сайншанд өртөөнөөс баруун тийш 60 км, Зүүнбаянгийн төмөр замын өртөөнөөс 40 км, Сайхандулаан сумын төвөөс зүүн урагш 46 км зайд, Дорноговийн нүүрс-занарын сав газрын баруун хэсэгт байрладаг.

Хүснэгт 1 Тусгай зөвшөөрөлтэй талбайн солбицлууд

Цэгийн дугаар	Талбайн солбицлууд	Газарзүйн солбицлын систем			Метрийн солбицлын систем /UTM/	
		Град	Мин	Сек		
1	Урттраг	109	31	18.42	Y	382602.977
	Өргөрөг	44	33	31.55	X	4934999.251
2	Урттраг	109	30	50	Y	381976.014
	Өргөрөг	44	33	31.55	X	4935010.633
3	Урттраг	109	30	50	Y	382022.894
	Өргөрөг	44	34	55	X	4937585.519
4	Урттраг	109	31	34.2	Y	382997.587
	Өргөрөг	44	34	55	X	4937567.843
5	Урттраг	109	31	34.2	Y	382997.587
	Өргөрөг	44	33	31.55	X	4934999.251



Зураг 1 “Өндөр жавхланта” нүүрсний ордын байршил

1.5 Уурхайн жилийн хүчин чадал

Ил уурхай нь 2 жилийн хугацаанд ашиглахаар ТЭЗҮ батлагдсан ба ашиглалтын эхний жил буюу 2023 онд 100 мян.тн нүүрс олборлоно. 2019-2022 онуудад хөрөнгө оруулалтгүй шалтгаанаар үйл ажиллагаа явуулаагүй болно. Уурхайн нь 2023 онд үйл ажиллагаа явуулахаар уулын ажлын төлөвлөгөө батлуулсан.

1.5.1 Уулын ажлын горим:

Уурхай нь 2023 онд хамгийн ихдээ 240 хоног ажиллана.

Уурхайн үйл ажиллагаа нь Вахтын системээр 28 хоног ажиллаад 14 хоног амрах, уурхай дээр 2 ээлжээр, ээлжийн үргэлжилэх хугацаа 12 цаг байх зохион байгуулалттайгаар ажиллана. Уурхайн жилд ажиллах цэвэр хоногийг монгол улсын хууль тогтоомжуудад заасны дагуу олон нийтээр амрах баяр ёслолын хоногуудаас цагаан сар, улсын баяраар амрах бусад олон нийтийн амралтын өдрөөр амрахгүй байх, мөн цаг агаарын хүндрэл, засвар үйлчилгээ зэрэг хүчин зүйлүүдийг хасч тооцсон байна.

1.5.2 Уулын ажлын төлөвлөлт

Хүснэгт 2 . 2023 оны календарчилсан төлөвлөгөө

Он	Улирал	Хөрс хуулалт, мян.м3	Нүүрс олборлолт, тн	Хөрс хуулалтын коэффициент
2023	II улирал	250.74	25.5	9.2
	III улирал	380.50	33.25	10.6
	IV улирал	369.76	41.25	11.7
Нийт		1001	100.0	10.5

1.5.3 Шимт хөрс хуулах:

Шимт хөрсийг Shantui SD23 маркийн бульдозероор түрж, дугуйт ачигчаар автосамосвалд ачиж шимт хөрсний овоолго руу тээвэрлэнэ. Шимт хөрсний овоолгыг 350 градусын налуутайгаар үерийн ус болон салхины нөлөө бага байх газар байгуулна. Шимт хөрсийг уурхайн талбай, овоолгын суурь, гүүрсний овоолго орчмын талбайгаас 0.3 метрийн зузаантайгаар хуулна. 2023 онд 19.78 мян.м3 шимт хөрс хуулж овоолно. Шимт хөрс хуулах, ачих, тээвэрлэх ажлын зардлыг хөрс хуулалт, тээвэрлэлтийн зардалд оруулан тооцно.

Хүснэгт 3 Бульдозерын бүтээл

Тэмдэглэгээ	Үзүүлэлт	Х.нэгж	Г дэх жил
	Бульдозерийн марк		5D23
	Ажлын мөргөцөг		Шимт хөрс
Vбт	Бульдозерын түрэх призмын эзлэхүүн	м3	4.63
hху	Хусуурын өндөр	м	1.39
Lху	Хусуурын өргөн	м	3.72
Вп	Түрэх призмийн налуугийн өнцөг	град	35.00
f	Чулуулгийн үрэлтийг тооцох коэффициент	-	0.9
a	Чулуулгийн алдагдлыг тооцох коэффициент		0.68
Lt	Бульдозероор чулуулгийг түрэх дундаж зай	м	80.00
Кба	Бульдозер ашиглалтын коэффициент		0.83
Кна	Гадаргын налууг тооцох коэффициент		0.36
tm	Бульдозерийн мөчлөгийн хугацаа	сек	157.32
ta	Түрэх чулуулгийг ухах цуглуулах хугацаа	сек	2.88
ta.я	Ачаатай чиглэлд явах хугацаа	сек	100.00
txy	Чулуулгийг хураах хугацаа	сек	10.00
tx.я	Хоосон чиглэлд явах хугацаа	сек	44.44
Кс	Чулуулгийн сийрэгжилтийн коэффициент		1.20
Qц	Бульдозерийн цагийн бүтээл	м3/цаг	21.59
T	Ээлжийн үргэлжилэх хугацаа	цаг	12
Qээлж	Бульдозерийн ээлжийн бүтээл	м3/ээлж	215.91
n	Ээлжийн тоо	ш	2
Qхоног	Бульдозерийн хоногийн бүтээл	м3/хоног	431.81

N	Жилд ажиллах хоног	хоног	200
Q жил	Бульдозерийн жилийг бүтээл	мЗ/жил	85,930.25

1.5.4 Уурхайн нээлт, ашиглалтын систем

Уурхайн нээлт: Ордын нүүрсний давхаргууд нь баруун хойш 45 градусаар унаж, баруун урдаас зүүн хойш суналтай байна. Уурхайн талбайг ордын зүүн хойд хэсгээс нүүрсний гаршид гадаад байршилтай капитал траншейгаар нээнэ.

Ашиглалтын технологи: Өндөр жавхланта орд нь налуу уналтай (45 град) тул уурхайн ашиглалт явуулсан талбайд дотоод овоолго хийх боломж орон зайн хувьд бүрдэхгүй байна. Ордын ашиглалтанд тээвэртэй гадаад овоолготой ашиглалтын систем ашиглана.

Хүснэгт 4 Ил уурхайн технологийн агуулга, бүрдэл

Технологи	Үндсэн ажил	Технологийн процессууд
Тээвэртэй, гадаад овоолготой ашиглалтын технологи	Хөрс хуулалт	Өрөмдлөг тэсэлгээ Ухаж ачих Тээвэрлэх Овоолох
	Олборлолт	Ухаж ачих Тээвэрлэх Овоолох (агуулахад хураах)

1.6 “Цахилгаан хангамж

Цахилгаан хангамжийн эх үүсвэр: Төвийн эрчим хүчний системд холбогдоогүй нутагт орших тул Борхулангийн нүүрсний уурхайн талбайг өөрийн эх үүсвэрээс дизель цахилгаан генератораас эрчим хүчээр хангана.

Цахилгаан ачааллын тооцоо: Уурхайн цахилгаан хэрэглэгчдийг тэжээх дизель генераторыг сонгохын тулд бүх цахилгаан хэрэглэгчийн тооцооны бүрэн ачааллыг тооцоо.

Хүснэгт 5 Цахилгаан хэрэглэгчдийн суурь болон тооцооны актив чадал

№	Цахилгаан хэрэглэгчид	Тоо, ширхэг	Суурилагдсан хүчин чадал, кВт		Хэрэглээний коэффициент	Чадлын коэффициент, Cos	Тооцооны чадал, кВт
			Нэгж	Бүгд			
1	Уурхайн гэрэлтүүлэг	10	0.5	5	0.6	0.6	1.8
2	Ахуйн хэрэглээ	1	150	150	0.85	0.85	108.375
3	Тэсрэх бодисын агуулах	1	8	8	0.6	0.6	2.88
4	Засварын хэсэг	1	120	120	0.9	0.8	86.4
Дүн				283			199.46

Хүснэгт 6 Төслийн цахилгаан хэрэглээ

№	Цахилгаан хэрэглэгч	Тооцонгчлалт, кВт	Ажиллах хугацаа			Цагашиглах коэффициент	Цахилгаан зарцуулалт, кВт.цаг		
			Хоног	Хоног	Цаг		Хоногт	1 дахь жилд	2 дахь жил
1	Уурхайн гэрэлтүүлэг	1.80	199	322	24	0.85	36.7	7,307.3	11,823.8
2	Ахуйн хэрэглээ	108.38	199	322	24	0.85	2,210.9	439,959.2	711,893.7
3	Тэсрэх бодисын агуулах	2.88	199	322	24	0.85	58.8	11,691.6	18,918.1
4	Засварын хэсэг	86.40	199	322	24	0.90	1,866.2	371,381.8	600,929.3
Нийт		199.46					4,172.6	830,339.8	1,343,565.0

Дээрх чадлыг үндэслэн, уурхайн тосгон, засварын хэсгийн 125 кВА чадалтай Komatsu-н 2 ш дизель генератороор тус тусад тэжээхээр тооцсон байна. Мөн ТБ агуулахыг эрчим хүчээр тэжээхэд агаарын шугамыг татах өртөг өндөр гарах тусд нь 1 ширхэг мөн 10 кВА-ын дизель генератораар тэжээхээр тооцжээ. Дизель генераторуудыг контейнераар тоноглоно.

1.7 Усан хангамж

“Өндөр жавхлант” ордын нүүрсийг олборлохтой холбогдон унд-ахуйн болон үйлдвэрлэлийн ус хангамжийн асуудлыг шийдэхэд чиглэсэн гидрогеологийн судалгааг тухайн хатуу ашигт малтмалын ордын нарийвчилсан хайгуулын дүн гарч уг ордыг ашиглах нь эдийн засгийн хувьд тодорхой болсон үеэс явуулдаг уламжлал байгаа учраас унд-ахуйн, техникийн усыг тухайн газраас газрын доорх усны орд илрүүлэн судлах шаардлагатай гэж үзжээ. Энд усыг дараах үндсэн 2 зориулалтаар хэрэглэнэ. Үүнд:

- Унд ахуйн ус хэрэглээ
- Технологийн /уурхайн зам талбайн усалгаа, техникийн/ ус хэрэглээ

Ажилчдын унд ахуйн усны хэрэглээ

Орд ашиглалтын үед уурхайн хотхонд 65 хүн амьдрах бөгөөд доорх хүснэгтэд хотхоны усан хангамжийн тооцоог үзүүлэв. Усны хэрэглээг ойролцоох малчны гар худгаас хангахаар төлөвлөсөн бөгөөд нэг хүний усны хэрэглээг (Байгаль орчин, Ногоон хөгжил, Аялал жуулчлалын яамны сайдын 2015 оны А/301 тоот тушаал) нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны түр нормын дагуу худгаас зөөврийн усаар хангадаг тохиолдолд 30 литр байхаар авав.

Хүснэгт 7 Усны хэрэглээ

Ажиллах жил	Ажилчдын тоо	хэрэглээ усны хоногийн Нэг хүний	усны Хоногт	дунджаар Ажиллах хоног	хэрэглээ Жилийн усны	хэмжээ ундаргын Шаардлагатай

Х.нэгж	хүн	л	м ³ /хон	хоног	м ³ /жил	л/с
2023 он	65	30	1.95	214	2086.5	0.022

Уурхайн хотхоны унд-ахуйн усны хэрэглээнд 2023 онд 2086.5 м³ ус хэрэглэнэ.

Замын усалгаа

Замын усалгааг 1.25 га талбайд жилд 120 хоног усалгааг хийнэ. (Байгаль орчин, Ногоон хөгжил, Аялал жуулчлалын яамны сайдын 2015 оны А/301 тоот тушаал) нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны түр нормын дагуу 1 м² талбайг 2л усаар усална. Жилд 3980.0м³ ус шаардлагатай.

Хүснэгт 8 Замын усалгаа

Ажиллах жил	Усалгаа хийх замын хэмжээ	Хоногт шаардлагатай усны хэрэглээ	Жилийн усны хэрэглээ	Шаардлагатай ундаргын хэмжээ
Х.нэгж	м ²	м ³ /хон	м ³ /жил	
1 дэх жил	12,500.0	22.5	3980	0.52

Ил уурхайн усны хэрэглээнд хамгийн ихдээ 0.54 л/с усны эх үүсвэр шаардлагатай ба 2023 онд 3980.м³ ус хэрэглэхээр байна.

2023 оны нийт усны хэрэглээ

Өндөр жавхлантагийн ордыг ашиглахад шаардлагатай нийт усны хэмжээг доорх хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 9 Төслийн 2023 оны нийт цэвэр усны хэрэглээ

А.жил	Усны хэрэглээ /м ³ /			Шаардлагатай усны эх үүсвэр /л/с/		
	Замын усалгаа	Унд ахуй	Нийт	Замын усалгаа	Унд ахуй	Нийт
2023 он	3980 мян.м ³	2086.5 м ³	6066.5	0.52	0.023	0.54

Ордыг ашиглахад шаардлагатай усны ундаргын хэмжээ 0.54л/с байна. Үүнээс замын усалгааг шүүрлийн ус, хур борооны усаар болон унд ахуйг 1л/сек ундаргатай гүний худгаас хангах боломжтой юм.

1.8 Туслах материал

1.8.1 Тэсэлгээний бодис.

Уурхайн олборлолтын үед хийгдэх тэсэлгээний үед дотооддоо үйлдвэрлэж буй энгийн найрлагат “Анфо” болон “Эмульс”-ийн тэсрэх бодисыг ашиглахаар төсөлд тусгасан бөгөөд эдгээр бодисыг ашиглан тэсэлгээ хийхэд бусад туслах материалууд шаардлагатай байдаг.

Хүснэгт 10 Ашиглалтын жилүүд дэх тэсэлгээний хэрэгслийн тооцоо

Жил	Цооногийн цэнэг д гчөөө (Booster)	Искра-С-6м 500м/с	Цочир дамжуулах шижим	Гал дамжуулах шижим	Реле-РП-Д	Капсюль	Тэсрэх бодис (Анфо)	Тэсрэх бодис (Эмульс)
Х.нэгж	шир	шир	м	м	шир	шир	тонн	тонн
2023 он	3064	3064	12,722	43	143	57	93.33	23.33

Эндээс харахад уурхайн ашиглалтын хугацаанд “Анфо” тэсрэх бодис 93.33 тн, “Эмульс” тэсрэх бодис 23,3 тн хэрэглэгдэх ба тэсрэх бодисыг “Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм”-д заасан заалтын дагуу уурхайн 3 сарын хэрэгцээнээс хэтрүүлэхгүйгээр тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг тэсрэх материалын агуулахад хадгална. Тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг Улаанбаатар хотоос тусгай зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ. Тэсрэх материал тэсэлгээний хэрэгслийг Налайх дүүрэгт орших үйлдвэрүүдээс худалдаж авна.

1.8.2 Шатах тослох материал

Тус уурхайн үйл ажиллагааны үед тэнд ажиллах машин механизм болон тоног төхөөрөмжид шатах тослох материал ашиглагдана. Үүнд жилд дунджаар 93164.5 л техникийн /тосолгооны/ тос, 1863290 литр дизель түлш ба бензин, хэрэглэхээр ТЭЗҮ-д тусгажээ. Эдгээр шатах, тослох материалыг бөөнөөр авч хадгалахгүй бөгөөд тухай бүр нь шатахуун түгээх ойрын станцуудаас авч байхаар төлөвлөжээ.

1.8.3 Цацраг идэвхит бодис.

Тус уурхайд цацраг идэвхит бодис хэрэглэгдэхгүй

1.9 Хог хаягдал

Уурхайн үйл ажиллагааны явцад үүсч бий болох хог хаягдлыг байгаль орчин, хүний эрүүл мэнд, амьдрах орчинд сөрөг нөлөөгүйгээр ангилан цуглуулж, тээвэрлэн устгах нь чухал юм.

Энд ихэвчлэн ахуйн хатуу, шингэн хог хаягдал гарна. Энэхүү бүлэгт ахуйн хатуу, шингэн хог хаягдлыг байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө багатайгаар хэрхэн цуглуулж, ангилан, дахин ашиглах, зайлуулах арга хэмжээнүүдийн талаар болон Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хог хаягдлын тухай хууль, холбогдох эрхзүйн актуудыг уг төслийн үйл ажиллагаатай уялдуулан тусгав.

Хатуу, шингэн хог хаягдал нь хүн ам, үйлдвэрлэлд хэрэгцээт газрын нөөцийг багасгах, хөрс, ус, агаарыг хорт бодис, хүнд металл, нян вирусээр бохирдуулагч гол эх үүсвэр болдог. Хатуу хог хаягдал нь удаан задарч бодисын эргэлтэд аажмаар орох ба задрах хугацаа нь удаан байдаг учраас байгаль орчинд хор хөнөөлтэй. Төсөл хэрэгжих явцад гарах хог хаягдлыг хэлбэрээр нь:

1. Хатуу
2. Шингэн
3. Хийн гэж ангилна.

Хүснэгт 11 Хог хаягдлын эх үүсвэрүүд

Хаягдлын ангилал	Анхдагч эх үүсвэр	Хог хаягдлын төрөл	Хог хаягдлыг устгах арга зам
Ахуйн аюулгүй хог хаягдал	Гал тогоо, ажилчдын амьдрах байр	Цаас, баглаа боодол, хүнсний хаягдлууд, шил, хуванцар, лааз.	Дахин боловсруулах: цаас, сав баглаа, боодол, шил, лааз Ландфил: Хүнсний хаягдал, гахайн аж ахуй эрхэлдэг иргэдэд өгч болох юм.
Ахуйн аюултай хог хаягдал	Гал тогоо, халуун ус ахуй уурхай оффис, ажилчдын байр	Цэвэрлэгээний бодисууд, будаг, принтерийн ашигласан картреж, өдрийн гэрэл, ашигласан батерей.	Дахин боловсруулах: принтерийн ашигласан картреж Овоолох: Флюоресцент гэрэл ба батерей
Уурхайн аюулгүй хаягдал	Газар шорооны болон барилгын ажил	Мод, баглаа боодол, асгарсан цемент, төмрийн хаягдал ба поошиг,	Дахин ашиглах: баглаа боодол, хаягдал төмөрлөг, Газар булах: шороотой цемент, үнс,
Ахуйн бохир шингэн	Ажилчдын гал тогоо, шүршүүр, бие засах газар	Ахуйн бохир ус, гадаргуугийн урсацтай холилдох (бороо орсны улмаас)	Ульдчилан сэргийлэх арга хэмжээ авах

Энгийн хог хаягдал: Ахуйн хог хаягдлын төслийн ажилчдаас үүсэн ахуйн шингэн бохир болон хатуу хог хаягдал үүснэ. Ажилчдаас үүсэх 55,2 тн/жил хог хаягдлыг хогийн цэгт цуглуулан орон нутагтай байгуулсан хог хаягдлын гэрээний дагуу жилд 2-3 удаа зөөвөрлөж хогийн нэгдсэн цэгт хүргэнэ.

Харин тус нүүрсний ордын үйл ажиллагааны 2 жилд 13.0 мян/м³ ахуйн шингэн хаягдал үүсэх бөгөөд хаягдлыг септик сиситем ашиглах шингээх байдлаар шийлдвэрлэж байгаа бөгөөд цаашдаа байгаль орчинд сөрөг нөлөө багатай технологиор бохирын асуудлыг шийдвэрлэх шаардлагатай.

Аюултай хог хаягдал:

Харин төсөлд ашиглах авто машинуудаас гарах аюултай хог хаягдал болох аккумулятор, хаягдал тосны филтер, хаягдал дугуй зэргийг хадгалах бөгөөд ажилласан тосыг дахин боловсруулах үйлдвэрт тушаах арга хэмжээ авна.

Ил уурхайд ашиглах авто машины тоо, тээвэрлэлтийн хэмжээ, хоногийн дундаж гүйлт тэдгээрийн засвар үйлчилгээний тоо хэмжээ зэргээс хамааруулан аюултай хог хаягдлын хэмжээг тодорхойлсон болно.

Төслөөс үүсэх аюултай хог хаягдлыг Засгийн газрын 2018 оны 05 сарын 02-ны 166 дугаар бүхий журмын дагуу Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх, тайлагнах журмын хавсралтын дагуу эх үүсвэр дээр нь ангилан цуглуулж түр хадгалан тээвэрлэж, аюултай хог хаягдлыг холбогдох маягтын дагуу бүртгэн хөтөлж, БОХ-3 тайланг орон нутагтаа 11 сарын 25-ны дотор хүргүүлж байхыг зөвлөж байна.

Автомат кропны тосыг 40000 км тутамд сольдог бол механик кропны тосыг 20000км тутамд солих шаардлагатай байдаг. Тухайн үйлдвэрлэгчээс шалтгаалан харилцан адилгүй байна. Хугацаандаа солиулаагүй тохиолдолд өнгө нь өөрчлөгдөж кроп бохирддог. Кропны тосыг автомат хүч дамжуулах ангийн тосолгооноос гадна гидрийн шингэний зориулалтаар хэрэглэнэ.

Хүснэгт 12 Улиралд гарах тосны хаягдал

Тоног төхөөрөмийн төрөл	Марк	Хүчин чадал	Ш/тоо	Улиралд гарах хаягдал /л/
Үндсэн тоног төхөөрөмж				
Өрмийн машин	Kaishan-KY140	110 мм	2	50
Хийн компрессор	Kaishan-LGCY-15/13	15 м ³ /мин	2	-
Экскаватор	Case-CX800LC	4.6 м ³	1	80
Бульдозер	Shantui SD23	5.4 м ³	2	260
Автосамосвал	HOWO-ZZ5507	50 тн	9	мотор 25, кроп 34 ,гидро шингэн 80 , досол 50 л
Утгуурт ачигч	Liugong-CLG877III	3 м ³	1	35
Нүүрсний гадаад тээврийн самосвал	Northbenz	100 тн	6	52*6
Уурхайн шүүрүүлийн усыг татах насос	Ebara MATRIX-5-9T/2.2M	7.8м ³ /цаг	1	-
Туслах тоног төхөөрөмж				
Суудлын машин	Land cruiser 78	5 хүн	2	18
Суудлын машин	Nissan yudi	5 хүн	2	12*2
Грейдер	Liugong-CLG418		1	-
Усны машин	ZZ1257N4641W	20 м ³	1	22-23
Түлшний машин	Dongfeng 5CBM	5 м ³	1	12-18
Хангамжийн машин	Hyundai Mighty	3т	1	10-18
Нийт				450-630 л

1.10 Уурхайн тээвэр

Уурхайн хөрс хуулалт, нүүрс олборлолтонд ашиглах автосамосвалууд нь ил уурхайгаас хуулах хөрс болон олборлох нүүрсийг уурхайн гол замаар тээвэрлэж хөрсний гадаад овоолго, нүүрсийг нүүрсний агуулах (түр овоолго) хүртэл тээвэрлэн хураана.

Дотоод тээвэрт БНХАУ-д үйлдвэрлэсэн Howo-ZZ5507 маркийн 50 тн даацтай автосамосвал ажиллана. Ил уурхайгаас олборлох нүүрсийг гадаад тээвэрт Дорноговь аймгийн Зүүнбаян сумын төмөр замын өртөө рүү тээвэрлэнэ. Иймээс уурхайн баруун хэсэгт нүүрсний агуулах үүсгэн 2-3 хоногийн нөөцтэй хураана. Агуулахаас утгуурт ачигчаар гадаад тээврийн машинд ачина.

1.10.1 Уурхайн дотоод зам:

Ордыг ашиглахад цаашид ашиглалтын хэтийн төлөв, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах, ахуйн эрүүл таатай орчинг бий болгох зорилгоор үйлдвэрлэлийн, бусад замуудын тоосжилтыг дарж, замын арчилгааг байнга хийж байх шаардлагатай.

Автозамын техникийн нөхцөл нь замын норм дүрмийн дагуу хоёр урсгалтай, замын зорчих хэсгийн өргөн тооцоогоор 8.2 м байна. Сонгосон өргөн нь 11 м, байна.

1.10.2 Нүүрсний гадаад тээврийн зам:

Нүүрс худалдах худалдан авах гэрээний дагуу “Мига эрин зуун” ХХК нь бүтээгдэхүүнийг БНХАУ-ын Эрээн хот хүртэлх тээврийг хариуцах бөгөөд гэрээний дагуу уурхайгаас олборлох

нүүрсийг нүүрсний түр овоолго /агуулах/-оос 45 км шороон замаар авто тээврээр тээвэрлэн Зүүнбаян сумын төмөр замын өртөө хүргэн цааш Замын-Үүд, Эрээн хилийн боомт руу төмөр замаар тээвэрлэнэ. Авто тээврийн зай 45 км, төмөр замын тээврийн зай 282 км байна. “Мига эрин зуун” ХХК нь бүтээгдэхүүн борлуулах гэрээний дагуу гадаад тээврийн авто тээвэр, БНХАУ-ын Эрээн хот хүртэлх төмөр замын тээврийг хариуцах бөгөөд худалдан авагч цааш тээврийг хариуцна.

Гадаад тээвэрт нүүрсийг 2536S northbenz чирэгч толгой бүхий хагас чиргүүлтэй шланзаар тээвэрлэнэ. Нүүрс тээвэрлэх 45км авто замаас тоос тоосжилт гарах учир замыг хатуу хучилттай болгох шаардлага гарч байна. Мөн уг замын зураг төслийн ажлыг боловсруулж Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийлгэх шаардлага тулгарч байна. Дорноговь аймгийн засаг даргын А/256 тоот дугаар бүхий тушаалаар Орон нутгийн чанартай авто замын чиглэл батлуулсан байна.



Зураг 2 Гадаад тээврийн маршрут

БҮЛЭГ. 2 БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДЛЫН ҮЗҮҮЛЭЛТ

2.1 Физик газарзүй:

Тусгай зөвшөөрлийн талбай нь физик газарзүйн ангиллаар Алтайн өмнөд говийн мужид хамаарах бөгөөд засаг захиргааны хуваариар Дорноговь аймгийн Сайхандулаан сумын нутаг байршина. Уул зүй Говийн бүсийн ой модгүй намхан уулсын толгодорхог ухаа гүвээт гадаргуутай. Тусгай зөвшөөрлийн талбайд баруунаас зүүн тийш сунаж тогтсон. Элгэн уул (1316.2 м), Буурал уул (1327), Баян-овоо (1263 м), Хамар-Овоо (1025.7 м), Хөтөл хар уул (1346.7 м), Хулан баянгийн овоо (1004.4 м), Их өлзийт овоо (1264.7) зэрэг салангид уулс хөгжсөн байна. Хамгийн үнэмлэхүй өндөртэй цэг нь Хөтөл хар уул (1346.7 м) байна. Уулс нь

чулуулгаас хамаарч өөр өөр тогтоц үзүүлнэ. Боржинлог чулуулгаас бүрдэх Элгэн уулууд нь дунд зэрэг хэрчигдсэн тэгш гадаргуутай хадан цохио бүхий гадаргууг үүсгэнэ. Харин бялхмал терриген чулуулгаас тогтох Буурал, Гүн (1266.9), Цагаан дэл (1156.7), Хуанзын хөтөл зэрэгт хуурай сайр жалгаар хэрчигдсэн гол төлөв шовх бөмбөгөр оройтой налуу хажуу бэлтэй толгодлог гадаргуу зонхилдог.

2.2 Усан сүлжээ

Төв азийн гадагш урсгалгүй ай савд багтах усан сүлжээ муу хөгжсөн нутаг юм. Улирлын цаг уур, хур тунадасны хэмжээнээс хамаарч усны горим ихээхэн хувьсамтгай. Хужир марз бүхий тойром, уулнаас эх авсан хуурай сайр элбэг боловч Хулангийн булаг, Могойн булаг бусад ганц нэг нэргүй булгаас өөр байнгын урсгалтай гол горхи байхгүй. Хуурай сайруудаар нь зөвхөн ширүүн бороотой үед шугаман угаадлаар түр зуур ус урсаж жижиг хотгорт тогтоол нуур үүсгэнэ. Сайрууд нь хэдэн км үргэлжлэх 50 м хүртэл өргөнтэй идэгдлийн түвшингээр янз бүрийн гүнтэй эрэг үүсгэж байдаг. Уулын бэл хормой налуу газраар хааяа талбайн угаагдал ч явагдана. Нуурууд нь уулс хоорондын хотгор хөндий багахан талбайд гүехэн устай тогтох ба ууршилт ихтэй учир түргэн ширгэж хатдаг. Нилээд том (0.5 км²) Сэвхүүлийн цагаан нуур, Хөтөлийн тойромын нуур заримдаа жилийн турш устай өнжинө. Нуурууд нь шорвог устай бөгөөд ширгэж хатсан тойром (шал)-д хужир марз үүссэн байдаг. Ахуйн зориулалтаар зөвхөн худгийн ус хэрэглэх ба хуурай сайр, нуур тойрмуудад усны түвшин ойр байдаг учир ихэнхдээ ийм газар уурхайн худаг малтаж гаргасан байна. Худгийн усны түвшин 1-3 м-ээс 4-7 м. Усны химийн найрлага, шинж чанарын талаар гидрогеологийн бүлэгт тодорхой бичсэн болно. Уур амьсгал Эх газрын эрс тэс говийн хуурай дулаан уур амьсгалтай. Хоногийн агаарын дулааны хэлбэлзэл ихтэй байдаг. Жилийн агаарын дундаж хэм 3.10 С, дундаж тунадас 100-150 мм байдаг. Нэгдүгээр сард -15-180 С хүйтэн, долоодугаар сард 20+250 С бөгөөд хамгийн их халуун долоо, найман сард +28+420 С, хамгийн хүйтэн арван хоёр, нэгдүгээр сард -300 С хүрнэ. Агаарын харьцангуй чийгшил нэгдүгээр сард 50%-аас доош, долоодугаар сард 40%-иас доош байна. Агаарын чийг багатай учир манан бараг ажиглагдахгүй, цасан бүрхүүл бараг тогтдоггүй. Жилийн тунадасын 70% орчим нь долоо, наймдугаар сард унадаг. Ерөнхийдөө салхи шуурга ихтэй, жилийн салхины дундаж хурд 3-10 м/сек байдаг. Энэ нь салхи хаах өндөр уул нуруу байхгүйтэй холбоотой. Салхи голдуу хойноос, баруун хойноос заримдаа 30 м/с хүчтэй салхилдаг. Хавар, намрын улирал удаан үргэлжилнэ. Өвөл цас багатай дулаан байна.

2.3 Хөрс

Говийн хөрсний их мужийн цөлөрхөг хээрийн бүсэд хамаарна. Хөрсний ерөнхий шинж нь ялзмагаар ядмаг карбонатжилт өндөртэй, ус чийгээр дутагдалтай нимгэн бор хөрс болно. Хөрс нь шаварлаг, элсэрхэг, сайргархаг, дайргархаг найрлагатай бөгөөд эдгээр нь өөр өөрийн бүрэлдэх орчинтой байна. Хөндий хотгорын төв хэсгээр шаварлаг, мараалаг хөрс тохиолдох ба сайргархаг дайргархаг бор хөрс нь ил гарсан хад чулуу бүхий толгой, бэл хормойгоор нимгэн бүрхэвч үүсгэж байдаг. Судалгаа явуулсан талбайн хойд хэсгээр бор шаргал өнгийн нилээд мараалаг ялзмагаар туйлын ядуу элсэрхэг хөрс зонхилдог. Уулсын өндөрлөг газруудаар элгэн хүрэн өнгийн нарийн мөхлөгт хөрс ховроор тохиолддог онцлогтой. Орон нутаг нь салхи, хуурайшилт ихтэй учир элэгдлийн гадаргуутай бөгөөд хөрс нь хийсэж зулгарах нөхцөлтэй юм.

2.4 Ургамалан бүрхэвч

Ботаник-газарзүйн мужлалаар говийн умард цөлөрхөг хээрийн мужийн Говийн умард дорнод дэд мужид хамаарна. Ус чийг багатай, эх газрын хуурай уур амьсгал, говийн хөрстэй учир Дорноговийн хэв шинжийн тачир сийрэг цөөн төрөл бүхий ургамлын бүрхэвч тархдаг. Бор

хөрсөнд мөчид үндэслэн ургах таана, хөмүүл, хялгана, хазаар өвс, монгол өвс, ерхөг хаа сайгүй тохиолдох бөгөөд уул толгодоос тал хөндийрүү нягтрал нь нэмэгдэнэ. Бутлаг ургамлаас уул толгодын бэл жалгаар бүйлс, баглуур, хар харгана, хөндий хотгороор алтан харгана, хармагийн бут, дэрс нилээд ургана. Хуурай сайруудад олон наст модлог ургамал хайлаас ховроор ургах ба грунтын усаар тэжээгдэнэ. Модлог бутлаг ургамлыг нутгийн иргэд түлш болон ахуйн хэрэглээнд ашиглах бөгөөд ааг шүүс сайтай нэг наст таана хөмүүл, чихэрлэг жимс хармагийг хүнсэнд хэрэглэдэг байна. Амьтаны аймаг Амьтны аймгийн хувьд говь хээрийн нутагшмал унаган зүйлийн олон төрөл бий. Туурайтнаас хээр талаар идээших хар сүүлт, цагаан зээр ховор, хөхтөн хулан сүрэглэн амьдрах ба уул хад асгаар аргаль, янгир цөөн тоотой байдаг. Махчин амьтдаас хярс, үнэг, өмхий хүрэн, гүйдлийн чанартай чоно, мануул байдаг. Мэрэгчдээс улирлын чанартай буюу өвөл ичдэг алагдаахай, огтоно, зараа, атигдаахай, үхэр огодой, туулай тохиолдоно. Мөлхөгчдөөс элбэг түгээмэл шинжтэй нь хонин гүрвэл, могой гүрвэл, могой байдаг бол шавьжнаас аалз, сохор хар, хэдгэнэ, царцаа, эрвээхэй болон бусад шулуун далавчтан байдаг. Жигүүртний хувьд болжмор, ногтруу, хадны тагтаа, элээ түүнчлэн хон хэрээ, бүргэд бусад шувуу амьдардаг. Хур бороотой нуур тойром усаар дүүргэгдсэн үед тогоруу, нугас, галуу, ангир амьдардаг.

2.5 Нийгэм эдийн засаг

Хүн ам маш сийрэг суурьшилтай, 1 км² талбайд 0.1-0.2 хүн ногдоно. Хүн ам нь халх ястан бөгөөд ихэнх нь нүүдлийн мал аж ахуй эрхэлдэг ардын аж ахуйтан байдаг. Сумын төвд засаг захиргааны байгууллага, эмнэлэг, дунд сургууль, дэлгүүр, холбоо, шатахуун түгээгүүрийн станц бусад үйлдвэр үйлчилгээний газруудтай. Эдийн засгийн хувьд Өмнөд Монголын эдийн засгийн дэд бүсэд хамрагдана. Эдийн засгийн гол салбар нь мал аж ахуй юм. Мөн улирлын чанартай ан агнуур, жуулчлал хөгжиж байна. Орон нутгийн ач холбогдолтой автозамын тээвэртэй, Улаанбаатар-Замын үүдийн төмөр замаас 60 км, Сайншанд-Зүүн баянгийн төмөр замаас 40 км алслагдсан байдаг.

2.6 Ордын судлагдсан байдал

Районы физик-газарзүй, эдийн засгийн нөхцөлөөс шалтгаалан 1936 оныг хүртэл тусгай зөвшөөрлийн талбай байрших дүүрэгт зөвхөн маршрутын тойм судалгаа хийгдэж байжээ. Тусгай зөвшөөрлийн 1935-36 онуудад В.К.Чайковский нар маршрутын судалгаа хийж үүний үр дүнд нэгдсэн товч тайлан бичиж 1:200 000-ны масштабын суурь дээр геологийн зураг зохиосон байдаг. Тайланд районы давхаргазүйн талаар анхны мэдээлэл тусгагдсан байлаг байна. Геологийн зурагт биет, бүрдлүүдийн хил заагийг бүрэн зураагүй, зурагласан хэсэг болон хоосон зай салаавчилсан, тектоник хагарлууд байхгүйгээс тойм маягийн судалгаа болсон байдаг байна. В.К.Чайковский шохойжингийн үе бүхий элсжин, занараас бүрдэх грау-ваккийн формацийн тунамал хурдсыг хамгийн эртнийхэд тооцож карбон-пермийн настай гэж үзсэн. Бөсөл-элсжингээс амьтны үлдвэр олсон боловч нас нь тодорхойлогдоогүй байна. Үүнээс дээш 600 хүртэл метр зузаантай хурдсыг мезозойн насанд хамааруулж дотор нь 7 давхаргадас ангилжээ. Интрузив чулуулгийг тектоник-маагмын герциний ба киммерийн үе шатанд хамааруулсан байна. Толь овооны мангааны илрэлийг илрүүлж судалсан. Тэд уг илрэлийг 2 км² талбай эзлэх 20 м зузаан палеогены хөрзөнд агуулагдана. Нөөц нь 80 мян.тонн гэж тодорхойлсон ба 1966 онд тэнд явуулсан эрэл-үнэлгээний ажлаар химийн шинжилгээгээр SiO₂ “ 42.16-82.36%, MnO “ 0.16-14.7%, Fe₂O₃ “ 0.95-4.86%, P “ 0.02-0.44%-ийн агуулга тогтоогдсон байна. 1935 онд дээрхийн зэрэгцээ В.Н.Бородько нар Сайхандулаан сумын ойролцоох Хонгорын хөндийд 1:50 000-ны масштабын гидрогеологийн зураглал, хайгуул-ашиглалтын ажил гүйцэтгэж тайлан бичихдээ геологийн тогтцын талаар В.К.Чайковскийн давхаргазүйн ангиллыг хэвээр авч, газар дорхи усны талаар мэдээлэл өгчээ. Уг хөндийд хуурай сайрын элс-хайрга, нүүрслэг занарын бөсөл гаралт чулуулагт агуулагдаж

буй ус ялгасан. Ирүүлсэн ус нь 0.4-0.85 г/л эрдэсжилттэй учир унданд хэрэглэж болно гэж дүгнэсэн ба бөсөлт болон нүүрслэг занарын зузаалаг дахь элсэрхэг үе нь 1.18-6.98 г/л эрдэсжилт бүхий шорвог ус агуулдаг, түүнийг унданд хэрэглэж болохгүй гэж үзсэн байна. В.А.Данилов нар (1952), Б.И.Браташ нар (1954)-ын судалгааны үр дүнд районы давхаргазүй, магматизм, тектоник, гидрогеологи, ашигт малтмалын талаар зохих мэдээлэл хуримтлагджээ. Тэд нар мезозойн хурдсыг нарийвчлан судалж, нефтийн хэтийн төлөвт үнэлгээ өгсөн байдаг. Эдгээр судалгаа нь төслийн талбай дахь мезозойн хурдсаар дүүргэгдсэн хөндийн захын өчүүхэн хэсгийг хамарч байгаа учраас төслийн талбайн талаар тоймтой мэдээллээр хомс байдаг байна. 1961-62 онд судалгааны талбайн доод хэсгээс цааш геологичайгуулын 336 дугаар анги А.А.Храповын удирдлагын дор 1:1 000 000-ны масштабын геологийн зураглал хийж тайлан (1962) бичжээ. Тэрээр төслийн талбайн структурын үр-гэлжлэл дээр протерозойн тунамал-метаморф бүрдэл, доод кембрийн замагт шо-хойжин, ордовикийн *Cyrtophylum Nychopora*, *Helilitido* зэрэг амьтны үлдвэр бүхий элсжин-цахиурлаг занар, дээд девон-доод чулуун нүүрсний харайрагийн давхаргадсын *Porodendron* ургамлын үлдвэр бүхий бөсөлт тунамал, бөсөлт-эффузив чулуулаг, дунд-дээд чулуун нүүрсний их хонгор овоогийн давхаргадсын эффузив чулуулаг, юрийн тогтолцооны эффузив, цэрдийн эффузив ба терриген хурдас, түүнчлэн палеоген ба неогены настай эффузив чулуулаг ялгажээ. Интрузив бүрдлүүдийг дотор нь доод, дунд, дээд палеозойн боржинлог болон суурилаг, хэт суурилаг чулуулаг гэж ангилжээ. Зураглалын ажлын явцад зэсийн нэлээд тооны жижиг илрэл тогтоосон байна. Уг 1:1 000 000-ны масштабтай геологийн зураглалаар районы давхаргазүй, магматизм, тектоник, ашигт малтмалын талаар орчин үеийн мэдээлэл, ойлголтыг нилээд хэмжээгээр бүрдүүлсэн гэж үзэж болно. 1:500 000-ны масштабтай геологи-гидрогеологийн судалгаа нь төслийн талбайг бүхэлд нь хамарна. Геологийн судалгаа нь архей, триасаас бусад насны төрөл бүрийн хувирмал, тунамал, галт уулын болон интрузив чулуулгийг олон улсын давхаргазүйн шатлалын дагууд ангилахад чиглэгдэж органик үлдвэрээр насыг нь ямар нэгэн хэмжээнд үнэмшилтэй тогтоожээ. Харин силурийн ба кайнозойн хурдсаас органик үлдвэр олоогүй учир насны талаар тойм үндэслэл өгсөн байна.

2.7 Геоморфологи

Геоморфологийн судалгааг геологийн зураглалын маршрутын хамт явуулж ирсэн бөгөөд түүнчлэн АГЗ-ийн тайлалт, геологи-газарзүйн байдалтай нь харьцуулан судалсан байна. Судалгааны талбай нь Дорноговь аймгийн Мандах, Сайхандулаан сумын нутаг дэвсгэрийг хамарсан Монгол улсын физик газарзүйн мужлалаар Төв Азийн талын их мужийн Халхын дундад өндөрлөгийн дүүргийн Өмнөд говийн тэгш өндөрлөгийн тойрогт (Ж.Бямба Геологийн асуудлууд, 290 тал, 2001 он) багтана. Гадаргуугийн хэлбэр дүрс өнөөгийн дүр төрхөө олоход геологийн тогтоц, тасралт эвдрэл, элэгдэл, идэгдлийн үйл ажиллагаа чухал нөлөө үзүүлсэн байна.

2.8 Гидрогеологи

Төслийн талбай нь гидрогеологийн мужлалаар (Н.А.Маринов, 1963) Дорнод монголын уулс хоорондын бүсэд хамрагдана. Цаг уур, хур тунадасын хэмжээнээс хамаарч талбайн хэмжээнд тархалттай байнгын болон түр зуурын урсгал ус, булаг, шанд худгуудын усны түвшин үргэлж өөрчлөгдөж байдаг. Тус талбайд өмнөх судлаачид В.И.Васильев (1968), В.К.Чайковский (1936), О.Намнандорж нар (1966), А.А.Архипов (1966) нар гидрогеологийн судалгаа явуулж байсан байна. Өмнөх судлаачдын судалгааны үр дүн, газрын доорхи усны хуримтлал, хөдөлгөөн, тэдгээрийн явагдах нөхцөл, ус агуулагч хурдас чулуулгийн гарал үүсэл, литологийн найрлага зэргийг харгалзан дараахь 10 уст бүрдэл ангилсан байна. Үүнд: „ Дунд-дээд девоны тунамал хурдсын уст бүрдэл „ Доод чулууннүүрсний тунамал-вулканоген хурдсын уст бүрдэл „ Дунд-дээд чулууннүүрсний вулканоген чулуулгийн уст бүрдэл „ Пермийн вулканоген-тунамал

хурдсын уст бүрдэл „ Юрийн тунамал хурдсын уст бүрдэл „ Доод цэрдийн хүрмийн уст бүрдэл „ Дээд цэрдийн хурдсын уст бүрдэл „ Палеоген-неогены хурдсын уст бүрдэл „ Дөрөвдөгчийн сэвсгэр хурдсын уст бүрдэл „ Интрузив чулуулгийн уст бүрдэл

Тектоник

Төслийн талбай нь Монгол улсын нутаг дэвсгэрийн уламжлалт мужлалаар Өмнөд Монголын түрүү варисцид (герцинид)-ын хэсэгт (Геология МНР, т.2) хамаарагдана. Говь-Хянганы структур-формацийн бүс: Энэ бүс нь талбайн өмнөд хэсэгт 1550 орчим кв.км талбай эзлэн хойт талаараа Сүхбаатарын бүсээс Сайхандулааны гүний хагарлаар зааглагдана. Мезо-кайнозойн структур-формац: Төслийн талбайд уулс хоорондын хотгорт хуримтлагдсан эх газрын молассын формацид хамаарагдах доод-дунд юрийн хамархөөвөрийн давхаргадас Буурал уулын арын болон Ар усны хотгорт илэрнэ. Уг хурдас нь өргөргийн дагуу тэнхлэг бүхий хотон структур үүсгэх бөгөөд 400-600 м зузаантай. Мөн уулс хоорондын хотгорт хуримтлагдсан эх газрын молассын формацид хамаарагдах дээд юрийн шарилын давхаргадсын хурдас Дэрсэн усны хотгорт илрэх бөгөөд 400 орчим метр зузаантай. Эх газрын рифтийн нөхцөлд үүссэн шүтлэгдүү вулканитын формацид хамаарагдах доод цэрдийн цагаанцавын давхаргадас баруун урдаас зүүн хойш цуварсан 3 талбайд илэрнэ. Түүний зузааныг 350 м гэж үзэж буй бөгөөд уг рифт хаагдах үед терриген фац (цахиурлаг цемент бүхий элжин, гравелит)-ийн 50 орчим метр зузаантай хурдас хуримтлагджээ. Платформын үе шатны эх газрын уулс хоорондын хотост хуримтлагдсан алаг өнгийн терригений формацид хамаарагдах дээд цэрдийн сайншандын ба баянширээгийн давхаргадас Номт худагийн ба Далайн зоогийн гэж нэрлэгдэх хотгоруудад өргөн тархалттай. Давхаргадсууд нь 300-400 м тус бүр зузаантай. Уулын бэл хормой, хөндий, хуурай сайруудад дөрөвдөгчийн галавын төрөл бүрийн гарал үүсэлтэй 5-15 м хүртэл зузаантай сэвсгэр хурдас хуримтлагдсан ба хуримтлагдсаар байна. Тасралт эвдрэлүүд: Хайгуулын талбай дахь тасралт эвдрэлүүд нь геологийн болон структурын хувьд гол үүрэг гүйцэтгэх бөгөөд нэлээд өргөн тархалттай тохиолдоно. Хагарлыг үүсвэрлэсэн цаг үе, чиглэл, унал, гүн, идэвхжил зэрэгт үндэслэн ангилах нарийвчилсан судалгаа хийгдээгүй учир тэдгээрийн онцлогийн талаар хойно тоймлон бичсэн байна. Гол хагарлуудыг масштабын хувьд структур-формацийн бүс заагласан гүний хагарал, формац заагласан орон нутгийн чанартай хагарал, формац дундын хагарал гэж ангилав. Дашрамд тэмдэглэхэд тасралт эвдрэлүүд нь янз бүрийн цаг үед, өөр өөр гүнд үүсвэрлэж, дахин сэргэж, залуу насны хагарлуудаар тасран шилжиж зөрсөн байдаг. Мөн хагарлууд нь ихэвчлэн босоо, хааяа налуу уналтай, зонхилон зүүн хойш ба өргөргийн дагуу чиглэлтэй бөгөөд баруун хойш болон уртрагийн дагуух хагарал нь насны хувьд харьцангуй залуу юм. Сайхандулааны гүний хагарал (I) нь судалгааны талбайн хойт хэсэгт бараг өргөргийн дагуу чиглэлтэй бөгөөд Сүхбаатарын ба Говь-Хянганы структур-формацийн бүсийг зааглан талбайд 40 гаруй км үргэлжилдгээс Хөх өндөр уулын араар 10 гаруй км газар дээрээ цахиржилтаар тод илэрч, түүнээс баруун тийш, Шавартын холбоогийн хөндий даган мезо-кайнозойн сэвсгэр хурдас доогуур үргэлжилнэ. Буурлын арын хагарал нь баруун хойш чиглэлтэй бөгөөд доод-дунд юрийн (J1-2hh) хотгоруудыг зааглан талбайн хэмжээнд 15 км үргэлжилнэ. Уг хагарал баруун хойшоо дээд цэрд ба неогены хурдас доогуур, зүүн урагшаа дээд юрийн хурдас доогуур тус тус 30 км хүртэл үргэлжилж байгаа нь лавтай Тэрээр дундлаг вулканитын (C2-3do) ба эх газрын молассын (J1-2hh) формацийг зааглана. Хайгуулын талбайн хэмжээнд формац дундын 17 томоохон хагарал ялгаж байна. Эдгээрийн 5 нь дунд-дээд девоны, 8 нь дунд-дээд карбоны, 4 нь хожуу пермийн цаг үед үүсжээ. Өндөр жавхлантагийн чулуун нүүрсний ордын геологийн тогтоц Өндөр жавхлантагийн чулуун нүүрсний орд нь Өмнөд Монголын түрүү варисцид (герцинид)-ын хэсэгт структур формацийн хувьд Говь-Хянганы бүсэд (хотгор), нүүрсжилтийн хувьд Дорноговийн нүүрс“занарын сав газрын баруун урд үзүүрт (Д.Бат-Эрдэнэ ангиллаар) доод-дунд юрийн хамархөөвөрийн формацийн тунамал-терриген хурдсанд агуулагддаг.

Чулуун нүүрсний орд нь тектоник хагарлаар хэрчигдэж хэд, хэдэн хэсэгт хуваагдсан нилээд нийлмэл тогтоцтой орд юм.



⊙ Хайгуулын цооног
 — Тектоник хагарал
 — "Мига эрин зуун" ХХК-ийн талбай
 — Нүүрсний давхраас

Зураг 3 Өндөр жавхлантгийн ордын тектоник хагарлаар хэрчигдсэн байдал

БҮЛЭГ.3 ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

“Мига эрин зуун” ХХК-ийн “Өндөр жавхлант” нүүрсний ордыг ил аргаар ашиглах төслийн хувьд байгаль орчны төлөв байдал, байгаль орчны эрх зүйн байдал зэрэг нь байгаль орчныг хамгаалах асуудалтай хэрхэн уялдах, төслийн үйл ажиллагаанаас хамрах нутаг дэвсгэрийн орчны бүрдэл хэсгүүдэд төслийн хэрэгжих үе шат бүрийн үйл ажиллагааны нөлөөлөл, түүнчлэн төслөөс байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг үнэлэн тогтоовол.

Хүснэгт 13 Төслөөс байгаль орчинд нөлөөлж болзошгүй сөрөг нөлөөллийн матриц

Байгаль орчны үзүүлэлтүүд	Сөрөг нөлөөлөл	Эерэг нөлөөлөл
	Ил уурхайн ашиглалтын үеийн сөрөг нөлөөлөл	
Экологи орчин		
Усны гидробионт		
Хөрсний микроорганизм	++	
Амьтадын тархац нутаг	+	
Физик орчны өөрчлөлт, бохирдол		
Усны чанар, нөөц /ундны ус/	++	

Агаар орчны тоосжилт	+++	
Хөрсний бохирдол	++	
Хөрсний эвдрэл, элэгдэл	+++	
Дуу, чимээний нөлөөлөл	++	
Байгалийн нөөц, ашиглалт		
Газар ашиглалт	+	
Бэлчээр	+	
Газар тариалан		
Эрдэс, түүхий эдийн нөөц	++	
Байгалийн гамшиг, хүний буруутай үйл ажиллагаа		
Үер ус, газар хөдлөл	+	
Байгалийн аюулт үзэгдлийн давтамж ихсэх		
Уурхайн үйл ажиллагаанаас үүдэлтэй осол	++	
Нийгэмд үзүүлэх нөлөөлөл		
Эрчим хүчний хангамж		
Усан хангамж	++	
Шинээр ажлын байр бий болох		++
Бүтээн байгуулалт		+++
Нүүлгэн шилжүүлэх асуудал гарах эсэх		
Хүн амын орлого өөрчлөгдөх		+
Эдийн засаг, байгаль орчин		
Хувь хүний орлого, татварын хэмжээ өөрчлөгдөх		+
Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх		++
Ажлын байр нэмэгдэх		+
Ядуурлыг бууруулах		
Газар ашиглалт нэмэгдэх	++	
Байгалийн үзэсгэлэн төрх байдал		
Байгалийн үзэмж доройтох	+	
Ландшафтын хэлбэр өөрчлөгдөх	+	
Тусгай хамгаалалттай газар нутагт нөлөөлөх		
Түүх, археологи, соёлын өв дурсгалт зүйл		
Түүхийн дурсгалт зүйлд нөлөөлөх		
Археологи, палеонтологийн олдворт нөлөөлөх		

+++ - их, ++ -дунд, + - бага зэрэг, хоосон бол тухайн объектод нөлөөлөлгүй гэж үзнэ.

Уурхайн олборлолтын үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлж болзошгүй нийт 31 үзүүлэлтийг сонгон авсанаас хөрсний микроорганизм, амьтадын тархац нутаг, агаар орчинд тоос үүсгэх, хөрсний бохирдол, элэгдэл эвдрэл, ойр орчинд дуу чимээ ихсэх, газар ашиглалт, бэлчээр хомсдуулах, байгалийн түүхий эдийн нөөц багасах, үер ус орж голын сайр гольдрил өөрчлөгдөх, уурхайн үйл ажиллагаатай холбоотой осол аваарь гарах, байгалийн төрх байдал ландшафт өөрчөгдөх зэрэг сөрөг нөлөөллүүд их, дунд, бага зэргийн эрчимтэйгээр нөлөөлж болзошгүй байна.

Харин байгалийн түүхий эрдэс баялагийг бүтээн байгуулалтын ажилд ашиглахад бэлэн болгох, нутгийн иргэдэд ажлын байр шинээр бий болгох зэргээр нийгэмд эерэг нөлөө үзүүлж болохоор байна.

Хүснэгт 14 Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл

Биосферийн элементүүд	Биосферийн элементүүдэд уулын үйлдвэрлэлийн үзүүлэх нөлөө	Гарч болзошгүй үр дагавар
Хөрс	<input type="checkbox"/> Хөрс хуулалт <input type="checkbox"/> Технологийн болон гадаад тээврийн зам байгуулах;	<input type="checkbox"/> Газрын гадаргуугийн деформаци, хөрсний элэгдэл, талбайн дүр төрхийн өөрчлөлт <input type="checkbox"/> Газрын доорхи усны багасалт
Ус	<input type="checkbox"/> Уурхайн усны хэрэглээг хянах <input type="checkbox"/> Ил задгай талбайд ус тогтох	<input type="checkbox"/> Газрын доорхи болон гадаргын усны нөөц, горим, чанар өөрчлөгдөх
Агаар мандал	<input type="checkbox"/> Агаарын тоосжилт, хорт хийн тархалт <input type="checkbox"/> Тээвэрлэлт, боловсруулалтын явцад тоосжилт үүсэх	<input type="checkbox"/> Тоосжилт <input type="checkbox"/> Агаарын бохирдол <input type="checkbox"/> Шатах тослох материалаар бохирдох
Ургамал	<input type="checkbox"/> Технологийн болон гадаад тээврийн зам байгуулах;	<p>„ Ургамлан нөмрөг устах, ургамлын төрөл зүйл хомсдох, бэлчээрийн ургамал хомсдоноос бэлчээрийн талбай багасах</p> <p>„ Автомашин, тээврийн хэрэгслийн дуу чимээ нэмэгдсэнээс ан амьтан дайжих, байршил тархалт нь өөрчлөгдөх, амьтдын амьдрах орон зай нь хумигдах</p> <p>„ Боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагааг дагалдаж, ан амьтны нөөц хорогдох, амьдрах орчин нь өөрчлөгдөх</p> <p>„ Мал амьтан ашиглалтын талбай руу орох, карьерт унах</p>
Амьтан	<input type="checkbox"/> Ашиглалтын талбайг ашиглах	

Хог хаягдал	<input type="checkbox"/> 56.6 м ³ ахуйн бохир ус гарах <input type="checkbox"/> 36.9 тн хатуу хог хаягдал үүсэх /жилд / <input type="checkbox"/> 450-630 л шатах тослох материал / улиралд/	<input type="checkbox"/> Ахуйн бохир усны хадгалалтын найдваргүй байдлаас хөрс, гүний ус бохирдох <input type="checkbox"/> Хатуу хог хаягдал үүсч цэгцтэй хадгалахгүй бол салхинд хийсч хөрс, орчин бохирдох үнэр тархах
--------------------	--	---

БҮЛЭГ. 4 БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГӨЛ ЗОРИЛТ

Бид хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж, компанийн ажилчид болон нутгийн иргэдийн аюулгүй байдал, эрүүл мэндэд хохирол учруулахгүй, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн бага түвшинд байлгах зорилго тавьж ажилладаг болно.

Үүний тулд дараах үндсэн чиглэлүүдэд анхаарч ажиллана. Үүнд:

- Үндсэн болон гэрээт ажилчид, орон нутгийн иргэийн эрүүл мэнд, аюулгүй байдал, байгаль орчинд сөргөөр нөлөөлж болзошгүй эрсдэлийг тодорхойлж, хянаж ажиллана.
- Монгол улсын хууль, тогтоомж, олон улсын нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн стандартыг дагаж мөрдөнө.
- Эрүүл, аюулгүй ажлын байр бий болгож, байгаль орчны бохирдол үүсгэхгүй байх нь ажилтан бүрийн үүрэг хариуцлага болгон бүрдүүлнэ.
- Бүх түвшний удирдах ажилтнууд байгаль орчин, хөдөлмөр аюулгүй байдал эрүүл ахуйн манлайлагч байж, ажилчдад үлгэр дуурайлал болно.
- Уурхайн үйл ажиллагаанаас байгаль орчин болон эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхүйц үр дагаварын тухай нутгийн иргэдээс мэдээлэл өгөх явдлыг урамшуулж хамтран ажиллана.

Эрх зүйн үндэслэл

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм.

Энэхүү төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжилтийг хангахдаа байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайланд тусгагдсан байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө болон орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг үндэслэн байгаль орчныг хамгаалах талаар авах удирдлага зохион байгуулалтын болон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ тэдгээрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хугацаа, хөрөнгө зардлыг бодитойгоор тооцож тусгах зорилт тавьсан.

Мөн Монгол улсын “Байгаль орчныг хамгаалах тухай” хуулийн 31.4 дэх заалт болон “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулийн 9.6, 9.7 дахь заалт, БОАЖ-ын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ийн өдрийн А/168 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”, Байгаль

орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний дүгнэлт, мөн нарийвчилсан үнэлгээний үр дүн зэргийг удирдлага болгов.

Бид төслийн үйл ажиллагаанаас хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс зайлс хийх, урьдчилан сэргийлэх, бууруулах, нөлөөллийг байж болох хамгийн бага хэмжээнд байлгах бөгөөд байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөөг хэрэгжилтийг хангаж, явцад нь хяналт тавин ажиллах болно.

А. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө

Аливаа төслийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны явцад байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөц баялгийг зохистой ашиглах үйл ажиллагааг зохистойгоор шийдвэрлэх арга зам, түүнд шаардагдах зардлыг хамруулан тусгасан баримт бичгийг “**байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө**” гэнэ.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний салшгүй нэг хэсэг бол байгаль хамгаалах төлөвлөгөө бөгөөд энэ төслийн үйл ажиллагааны явцад хүрээлэн буй орчинд учруулж болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, үүссэн нөлөөллийг бууруулахад барьж ажиллах төлөвлөгөө болно.

Хүрэн нүүрсний ордыг ашиглах төслийн байгаль хамгаалах төлөвлөгөөг боловсруулахдаа байгаль орчны тухай хуулиуд болон тэдгээртэй холбогдон гарсан дүрэм, журам, стандартуудын дагуу төслийн үйл ажиллагааны улмаас үүсэж болзошгүй болон голлох сөрөг нөлөөллийг бууруулахын тулд авах арга хэмжээ, түүнд шаардагдах зардлыг тусгалаа. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг бүрэн хэрэгжүүлсэн нөхцөлд төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд учруулах сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, байгалийн нөөц баялгийг зүй зохистой ашиглах боломж бүрдэхээс гадна төслийн хэрэгжих чадварыг дээшлүүлж, эдийн засгийн үр ашиг нэмэгдэнэ.

Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний явцад тогтоогдсон төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, түүнээс урьдчилан сэргийлэх, үр дагаврыг арилгах арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, зарцуулах төсөв, баримтлах эрх зүйн баримт бичиг зэргийг тодорхойлон нэгтгэж тусгалаа.

Хүснэгт 15 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл	Хамрах хүрээ	2019 оны зардал	Хугацаа, давтамж	Авч хэрэгжүүлэх арга хэмжээ	Баримтлах хууль, журам, стандарт
АГААРЫН ЧАНАР					
Нүүрс олборлох, тээвэрлэх явцад тоос тоосжилт салхиар дамжин агаарт дэгдэх	Нүүрсний ордыг ашиглах уурхайн ажилчид, болон ойр орчмын үйлдвэрийн ажилчид, оршин суугчид	ОХШ-ний хөтөлбөрт	Төслийн бүх үе шатанд	Ажилчдын байрны тойронд мод тарих, ургамалжуулах зэргээр болон зам талбай, хаягдлыг усалж тоосжилтыг бууруулах арга хэмжээ авах	“Агаарын тухай” болон “Агаарын бохирдлын төлбөрийн тухай” хууль/2012.05.17/ MNS 0017-2-3-16:1998(Суурьшилын хэсгүүдэд) MNS 4585:2007 Агаарын чанар.Техникийн ерөнхий шаардлага
				Агаарын чанарт тавих хяналтын хүрээнд уурхай орчмын агаар дахь хорт бодис(H ₂ SO ₄ , SO ₃ , SO ₂)-ын агууламжийг тодорхойлж байх	Агаарын тухай болон агаарын бохирдлын хууль /2012.05.17/ MNS 0017-2-3-16:1998 Галын аюулгүй байдлын тухай хууль/2012.05.17/ ”Гамшгаас хамгаалах тухай” хууль
Түлш шатахуун асгарч алдагдсанаас орчны агаар бохирдох	Уурхай орчимд	Үйл ажиллагааны зардалд	Олборлолт, боловсруулалтын бүх үе шатанд	Техникийн засвар үйлчилгээг тогтмол хийж байх	
УСАН ОРЧИН					

<p>Ахуйн бохир ус хадгалах савны найдваргүй байдлаас бохир ус гүний ус руу алдагдах, хатуу, шингэн хог хаягдлыг ил задгай хаях,шатах тослох болон химийн материал асгарч, гоожсон тохиолдолд тэдгээр нь бороо- цасны усаар угаагдан хөрсөнд нэвчиж шингэснээр хөрс, улмаар гүний усыг бохирдуулах</p>	<p>Уурхай орчим ажилчдын байр, засварын газар</p>	<p>400.0</p>		<p>Төлөвлөлт, олборлолтын эхэн үе шатанд</p>	<p>Бохирын савны бүрэн бүтэн байдлыг хангах, шатах, тослох материал алдагдахаас сэргийлэхийн тулд гаднах талбайг цементээр хучих</p> <p>Ажилчдын хотхонд амьдарч байгаа бүх хүмүүст болон ажлын байранд усны хэмнэлтийн талаар мэдээлэл өгөх, сурталчилгаа самбар байршуулах;</p> <p>Төслийн талбайд бий болсон түр зуурын урсацууд, ил задгай ус үүсвэл дээж авч бохирдлыг тодорхойлох</p>	<p>“Усны тухай” хууль/2012.05.17/ “Рашаан, ус ашигласны төлбөрийн тухай” хууль. Усны нөөцийг бохирдлоос хамгаалах дүрэм. БО болон ЭМ-ийн сайд нарын хамтарсан тушаал 167/335/A171 MNS 4586:1998 Усан орчны чанарын үзүүлэлт. MNS 3342:1982 Газрын доорх усыг бохирдлоос хамгаалах</p>
<p>ХӨРС, УРГАМЛАН БҮРХЭВЧ</p>						
<p>Хөрсний овоолго болон уурхайн олборлолтоо</p>	<p>Ил уурхай, барилга байгууламж,</p>				<p>Ил уурхай болон газар эвдэх бусад үйл ажиллагаануудыг эхлүүлэхээс өмнө үржил шимт хөрсийг стандартын дагуу</p>	<p>MNS5850-2008, “Хөрсний чанар, хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх</p>

р сүйтгэгдэх хөрс				хуулж, овоолох; Ажилчдын тосгоны орчны тоосжилт их босдог газруудыг чийглэж, норгох	дээд хэмжээ”
Газрын гадарга, хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөг үйлдвэрийн барилга байгууламжид, зам талбайд дарагдаж элэгдэл эвдрэлд орох	Ил уурхайн хүрээнд	500.0	Төсөл хэрэгжих бүх хугацаанд	Зөвшөөрөлгүй зам дээр явах машины хурдыг хязгаарлах, тэмдэгжүүлэх; Хөрсний бохирдол үүсгэхээс сэргийлэх болон олон салаа зам гаргахгүй байх талаар инженер, жолооч операторуудад сургалт зохион байгуулах;	MNS58163-2008, ”Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт”
АМЬТАН					
Ашиглалтын талбай орчмын амьтадын амьдрах орчин доройтох, дуу чимээнээс үргэж дайжих	Ил уурхай,	500.0	Төсөлд эхлэхээс болон хэрэгжих бүх үе шатанд	Уурхайн талбай болон түүний эргэн тойронд зэрлэг ан амьтадын мониторинг хийнэ; Уурхайн ажилчдад амьтан хамгаалах талаар сургалт хийнэ; Орон нутгийн байгаль орчны газрын хэрэгжүүлж буйамьтан хамгаалах арга хэмжээнд оролцож хамтран ажиллах Уурхайн карьерт амьтан орохоос сэргийлж хийсэн торон хашааны бүрэн бүтэн байдлыг хангаж байх	

Уурхайн ажилчдад байгаль орчныг хамгаалах сургалт, сурталчилгаа зохион байгуулах		400.0	Төсөл хэрэгжих бүх хугацаанд	Тогтмол хуваарийн дагуу байгаль хамгаалах сургалтыг уурхайн нийт ажигчдад зохион байгуулах, мэдээллийн самбарт сурталчилгаа байршуулах
Уурхай болон угаах үйлдвэрийн ажилчдад ХАБ-н сургалт тогтмол явуулах	Өндөр жавхлант уурхайн ажилчид	400.0		Тусгай хөтөлбөрийн дагуу сургалтыг зохион байгуулах, шинээр ажилд орсон хүмүүсийг ажилд орохын өмнө сургалтанд хамруулж, шалгалт авах
ХОГ ХАЯГДАЛ				
Ахуйн шингэн болон хатуу хог хаягдал хүрээлэн буй орчин, хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх	Ажилчдын байр,	200.0	Төсөл эхлэхээс дуусах хүртэл бүх шатанд	Шатах, тослох материалын хаягдал, асгаралт гаргахгүй байх, хяналттай анхааралтай ажиллах; Аюултай хортой хог хаягдлыг /аккумулятор, баттерей, ашиглагдсан шатах тослох материал, хаягдал дугуй/ худалдаж авдаг мэргэжлийн байгууллагад тушаах
Нийт зардал		2400.0		

Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

Тус ордыг 2 жилийн хугацаанд ил аргаар ашиглахаар 2018 онд ТЭЗҮ батлагдсан бөгөөд 2019-2020 онд covid цартахлын улмаас үйл ажиллагаа явуулаагүй болно. Харин 2021-2022 онд хөрөнгө оруулалтгүйн улмаас мөн үйл ажиллагаа явуулж амжаагүй болно. Уурхайн ашиглалтын үйл ажиллагааг 2023 онд эхлүүлэхээр төлөвлөн уулын ажлын төлөвлөгөөг боловсруулан батлуулсан. 2023 онд ашиглалтын эхний жил тул биологийн болон техникийн нөхөн сэргээлтийн ажил төлөвлөгөөгүй болно.

Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

“Өндөр жавхланта” нүүрсний ордыг 2 жилийн хугацаанд ашиглах ТЭЗҮ-г боловсруулан ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн батлуулсан ба ордын нөөцийг цааш нь нэмэгдүүлж ашиглалт явуулах тул уурхайн хаалт нөхөн сэргээлтийн ажил хийгдэх хугацаа тодорхойгүй зэргийг харгалзан үзэж уурхайн ашиглалтын явцад дүйцүүлэн хамгааллын ажлыг хийх шаардлагатай гэж үзэж байна.

Дүйцүүлэн хамгааллын арга хэмжээг хэрэгжүүлсэнээр төслөөс үүсэх сөрөг нөлөөлөл түүнийг бууруулж арилгах боломжгүй хүчин зүйлүүд, нөлөөллийн түвшинг төслийн судалгааны ажлын үед тодорхойлоогүй хүчин зүйлс /амьтадын амьдрах орчин, нүүдэл/ тэдгээрийг төслийн хэрэгжих орчны экосистем, биологийн олон янз байдлын хувьд төсөөтэй төсөл хэрэгжих орчныг төлөөлж чадахуйц талбайг сонгон авч хамгааллын арга хэмжээний ажлуудыг тогтоосон хугацаанд хэрэгжүүлсэнээр орчны нөхцлийг сайжруулахад үндсэн гол зорилго оршино.

Төслийн нөлөөлөлд өртөх газрын хэмжээг тогтоох: Төслийн нөлөөлөлд өртөх газрын хэмжээний талаарх суурь мэдээллийг БОННУ-ний тайлангаас үзэж болно. Хэрэв БОННУ-ний тайланд биологийн олон янз байдалд үзүүлэх орон зайн нөлөөллийн талаар хангалттай мэдээлэл байхгүй бол нэмэлт судалгаа хийх шаардлагатай. Биологийн олон янз байдалд үзүүлэх нөлөөллийг харьцангуй бодитойгоор тогтоох нь ямар хэмжээний газарт, ямар төрлийн дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг, ямар хугацаанд хэрэгжүүлэх гэх мэт чухал асуудлуудыг тодорхойлох үндэс болно. Нөлөөлөлд өртөж болзошгүй амьтан, ургамлын зүйл тус бүрт ямар нөлөөлөл үзүүлэх, нөлөөлөлд ямар хариу үйлдэл үзүүлэх зэргийг тэр бүр нарийвчлан тогтоох боломжгүй тохиолдолд нөлөөллийн индексийг ашиглан амьдрах орчинд үзүүлэх нөлөөллийн хэмжээг тогтоож болно. 2023 онд уст цэг нэмж барих бөгөөд, геотехникийн арга хэмжээг доорхи хүснэгтэд үзүүлэв.

Он	Төсөвлөгдсөн зардал: мян/төг	Ус зөөвөрлөх худгийн нэр:	Талбайн хэмжээ:м	Уст цэг барьж байгуулах талбайн солбицол:	Гүйцэтгэгч байгууллага:
2023	1200.0	Хулангийн ус	S= 10м*0.5м H(гүн)=0.3м	109°34'6.16"E 44°34'45.05"N	“Мига эрин зуун”ХХК
2023	1200.0	Хулангийн ус	S= 10м*0.5м H(гүн)=0.3м	109° 33.526'E 44° 34.152'N	“Мига эрин зуун”ХХК

Хүснэгт 16 Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ, зардал

Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө

“Өндөр жавхланта” нүүрсний ашиглалтын талбай орчимд ямар нэгэн айлын өвөлжөө, хаваржаа байхгүй бөгөөд нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ

төлөвлөх шаардлагагүй болно. Харин төслийн явцад уурхайн зүгээс ойролцоор малчид ард иргэдтэй уулзалт хийж аюулгүй ажиллагаа талаас зөвлөгөө өгч байх шаардлагатай.

Түүх соёлын дурсгалт зүйлсийн менежментийн төлөвлөгөө

“Өндөр жавхлантагийн” хүрэн нүүрсний ордын талбайд түүх дурсгалын болон соёлын өв болох зүйл байхгүй болно.

Цаашид нүүрс олборлох явцад илэрсэн түүх, соёлын дурсгалт зүйл илэрсэн үед “Монгол Улсын Үндсэн хууль”-ийн I бүлгийн 7-р зүйлд “Монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйл, шинжлэх ухаан, оюуны өв төрийн хамгаалалтад байна” гэж заасны дагуу түүх, соёлын өвийг эрэн сурвалжлах, бүртгэх, судалж шинжлэх, зэрэглэл тогтоох, үнэлэх, хадгалж хамгаалах, сурталчлах, сэргээн засварлах, өвлүүлэн уламжлуулахтай холбоотой үүрэг хариуцлагаа мөрдөж ажиллах нь зүйтэй.

Соёлын ба үнэт өв зүйлсийг илрүүлж, тэр нь олборлолтын үйл ажиллагаанд эрсдэхээр байвал засаг даргаас энэ үйл ажиллагааг даруй зогсоохыг шаардах, бололцоотой бол эдгээр газруудыг аль болох зохистойгоор хамгаалахыг хуульд заасан байдаг. Боловсрол, Соёл, ШУ-ны Яамны тусгай зөвшөөрөлгүйгээр зөөж шилжүүлэх боломжгүй соёлын ба үнэт дурсгалын өвийг малтах, зөөх, эвдэхийг хуулиар хориглосон.

Төслийн талбайд нүүрс олборлох болон төслийн үйл явцад ямар нэг түүх соёлын дурсгалын шинжтэй зүйл илрүүлсэн тохиолдолд Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 37.2-ийн дагуу холбогдох байгууллага, албан тушаалтанд нэн даруй мэдэгдэх, боломжтой бол хамгаалах арга хэмжээ авах үүрэгтэй.

Төслийн талбайд нүүрс олборлох болон төслийн үйл явцад ямар нэг түүх соёлын дурсгалын шинжтэй зүйл илрүүлсэн тохиолдолд Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 37.2-ийн дагуу холбогдох байгууллага, албан тушаалтанд мэдэгдэх үүрэгтэй. Болзошгүй зардал **500.0** мян/төг төсөвлөв.

Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Тус хүрэн нүүрсний ордыг ашиглах төсөл нь хөрс хуулалт, нүүрс олборлолт, нүүрс бутлах зэрэг үйл ажиллагаа гүйцэтгэх болно. Тус төслийн хувьд ил уурхайн хөрс хуулалтын шатанд тэсэлгээний ажил хийгдэх үед тэсэлгээний бодис хэрэглэнэ. Тиймээс үйл ажиллагааны явцад техник, тоног төхөөрөмжийн аюулгүй байдлыг хангаж ажиллах шаардлагатай.

Хүснэгт 17 Болзошгүй аюул осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөөний төсөв

Хийгдэх ажил	2023 оны зардал мян/төг	Хариуцах эзэн
Болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ		
Ажиллагсдыг хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэгслээр бүрэн хангах, хэрэглэж хэвшүүлэх	1500.0	Уурхайн дарга
Уурхайн ажилчдад тоосжилтоос хамгаалах амны хаалт авч өгөх	300.0	Компаний удирдлага
Болзошгүй эрсдэл тохиолдсон үед авах арга хэмжээ, эрсдлийг бууруулах, арилгах арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай эрсдлийн сан үүсгэх, байнгын бэлэн байдалд байлгах	300.0	Компаний удирдлага

Эрсдэл тохиолдсоны дараа авах арга хэмжээ, хяналт мониторинг		
Эрсдэл тохиолдсон үед авах арга хэмжээ, зааврын талаар ажиллагсад тогтмол сургалт явуулах, анхааруулах, хулээн авах чадварыг сайжруулах	Дотоод зохион байгуулалтаар	Уурхайн удирдлага, ХАБ-ын инженер
Эрсдэлд өртсөн жолооч, ажиллагсад, ойр орчмын хүн амыг эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамруулах, өвчлөлийг бүрэн эмчлэх, тусалж дэмжих		
Эрсдлийн улмаас бохирдолд өртсөн тухайн орчин болон агуулах орчим бодис тархсан эсэхэд хяналт, мониторинг хийх		
Осол эрсдэлд өртсөн эд хөрөнгө, тоног төхөөрмжийн хохирлыг тооцох, хэвийн үйл ажиллагааг хангах үүднээс засвар, шинэчлэлийн ажлыг хийх, дахин эрсдэл үүсэхээс сэргийлэх		
Галын аюулыг хурдан хугацаанд арилгах, үнс нурам, хог хаягдлыг хийсэх, орчинг бохирдуулахаас сэргийлж цуглуулах, зохих журмын дагуу устгах, хяналт тавин ажиллах		
Нийт зардал	2100.0	

Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Энгийн хог хаягдал: Ахуйн хог хаягдлын төслийн ажилчдаас үүсэн ахуйн шингэн бохир болон хатуу хог хаягдал үүснэ. Ажилчдаас үүсэх 35.6 тн/жил хог хаягдлыг хогийн цэгт цуглуулан орон нутагтай байгуулсан хог хаягдлын гэрээний дагуу жилд 2-3 удаа зөөвөрлөж хогийн нэгдсэн цэгт хүргэнэ.

Харин тус нүүрсний ордын үйл ажиллагааны жилд 1.33 мян/м³ ахуйн шингэн хаягдал үүсэх бөгөөд хаягдлыг септик систем ашиглах шингээх байдлаар шийлдвэрлэсэн бөгөөд цаашдаа байгаль орчинд сөрөг нөлөө багатай технологиор бохирын асуудлыг шийдвэрлэх шаардлагатай.

Аюултай хог хаягдал:

Харин төсөлд ашиглах авто машинуудаас гарах аюултай хог хаягдал болох аккумулятор, хаягдал тосны филтер, хаягдал дугуй зэргийг хадгалах бөгөөд ажилласан тосыг дахин боловсруулах үйлдвэрт тушаах арга хэмжээ авна.

Ил уурхайд ашиглах авто машины тоо, тээвэрлэлтийн хэмжээ, хоногийн дундаж гүйлт тэдгээрийн засвар үйлчилгээний тоо хэмжээ зэргээс хамааруулан аюултай хог хаягдлын хэмжээг тодорхойлсон болно.

Төслөөс үүсэх аюултай хог хаягдлыг Засгийн газрын 2018 оны 05 сарын 02-ны 166 дугаар бүхий журмын дагуу Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх, тайлагнах журмын хавсралтын дагуу эх үүсвэр дээр нь ангилан цуглуулж түр хадгалан тээвэрлэж, аюултай хог хаягдлыг холбогдох маягтын дагуу бүртгэн хөтөлж, БОХ-3 тайланг орон нутагтаа 11 сарын 25-ны дотор хүргүүлж байхыг зөвлөж байна. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг гүйцэтгэхэд жилд 1800.0 мян. төгрөг зарцуулахаар төлөвлөллөө.

Хүснэгт 18 “Өндөр жавхлант” хүрэн нүүрсний ордыг ашиглах төслийн хүрээнд гарах хог хаягдлын ангилал, устгах арга зам

Хэмжих нэгж	Эх сүвэрээсүү гарах хог хаягдлын төрлөө	Код	Аюулын зэрэглэл	Жилд нийт гарах хэмжээ (Шингэн)	Дахин боловруула	Хадгала	Ландфил	Устгах	Иргэдэд	Тайлбар	
Ахуйн /шингэн-ш /Х/	Хуванцар сав	T03 01	-	2023 онд- 25.8 тн						Борлуулах	
	Шил									ОНИ-д олгох	
	Лааз										
	Сүү, жимсний										Хог хаягдлын цэгт хүргэнэ
	Цаасан хайрцаг										Сайн цаас ,хаягдал цаас авдаг газарт тушаах
	Уут шуудай										
Ахуйн /шингэн-ш /Х/	Ахуйн бохир	T03 05	-	130-200ш дугуй гарна.							
	Хоолны хаягдал	A01 01	-							“Инархис”ХХК-д нийлүүлэх	
	Том жижиг дугуй									ОНИ-д олгох	
	Хаягдал мод										
	Агаар филтер шүүгч										Хог хаягдлын цэгт хүргэнэ
Ахуйн /шингэн-ш /Х/	Үнс			-							
	Аккумулятор	Ө06 05 Ө01 01 001 09	-	Тодорхойгүй						Тусгайлан цуглуулж хадгалах	
	Тосны хаягдал шүүлтүүр	Ө06 05 Ө01 01 001 09	-	Тодорхойгүй						Тусгайлан цуглуулж хадгалах мэргэжлийн байгууллагад тушаах	
Ахуйн /шингэн-ш /Х/	Тостой даавуу, бээлий										
	Ажилласан тос									“Алтан оршихуй групп” ХХК-д хаягдал тосыг тушаах	

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Үйл ажиллагаандаа технологийн сахилга батыг чанд баримталж, аваар осолгүй ажиллах талаар байнга анхаарал тавихыг уурхайн дарга болон хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны мэргэжилтэнгүүд хариуцан ажиллана. Доорх ажлуудыг компанийн захирал тушаал гаргаж баталгаажуулна.

Хүснэгт 19 Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

№	Хийгдэх ажил	Холбогдох хууль, дүрэм, журам, стандарт
1	Экологийн паспорт хөтлөх	Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 31.1.6
2	Галын аюулгүй байдлын дүгнэлт авах	Онцгой байдлын ерөнхий газраас
3	Байгаль орчны 2023 оны менежментийн төлөвлөгөөг хуулийн дагуу хэрэгжүүлэх Биелэлтэнд хяналт тавьж ажиллах	БОМТө-ны хяналт
4	Байгаль орчны аудит 2 жил тутамд хийлгэх	Байгаль орчныг хамгаалах тухай хууль
5	Хог хаягдлын талаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эрх, үүргийг биелүүлэх арга хэмжээ авч ажиллах	Хог хаягдлын тухай хуулийн 10 дугаар зүйл
6	Гамшгийн эмзэг байдал эрсдлийн үнэлгээ хийлгэх	Гамшгаас хамгаалах тухай

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь тухайн төслийг хэрэгжүүлэхдээ байгаль орчин, оршин суугчдын эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийн бууруулах, хяналт тавих зэрэг арга хэмжээ орох тул тухайн онд ямар арга хэмжээ төлөвлөж ажиллахыг орон нутгийн оршин суугчид, оролцогч талуудын оролцоо зайлшгүй байх ёстой зүйл юм.

Тиймээс төсөл хэрэгжүүлэгч жил бүр байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад дараах хүснэгтэнд заасан хуваарийн дагуу тайлагнахаас гадна шаардлагатай үед орон нутгийн иргэдтэй хамтран ажиллавал зохино.

БОМТ-г танилцуулах, хэрэгжилтийг тайлагнах хуваарь

БОМТ хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд	Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээллийн агуулга	Хугацааны тов	Хэлэлцүүлгээр санал авах чиглэл	Зохион байгуулах газар
БИНХ	Хурал	Тайлан ирэх оны төлөвлөгөө	БИНХ	БОХ арга хэмжээний тайлан ирэх оны төлөвлөгөөний төсөл	Багийн төв
Захирамжаар томиологдсон комиссын гишүүд	Комиссын шалгалт, хурал	тайлангийн хэрэгжилтийг шалгах	12-р сарын 1 өмнө		Уурхай
БОАЖЯам	Албан бичиг	Тайлан Ирэх оны төлөвлөгөө	12-р сарын 31		Улаанбаатар хот

ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт нөлөөлөлд өртөх болон өртөж болзошгүй байгаль орчны бүрдэл хэсгүүд, тэдгээрийн төлөв байдлыг тодорхойлох үзүүлэлтүүд, тэдгээрт хэмжилт, дээжлэлт хийх шинжилгээний аргууд, хяналтын цэгийн байршил, хяналт хийх хугацаа ба давтамж зэргийг ажлын хэмжээг хэмжих нэгж, нэгжийн үнэ, нийт зардал, баримтлах стандарт, аргагүй, аргачлалын хамт тусгаж боловсруулан оруулсан. Нүүрсний уурхайн талбайн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийн цар хүрээ, эрчмийг харгалзан үзэж, төслийн талбай болон түүний орчны бүсийн талбайг хамран байгаль орчны хяналт шинжилгээг жил бүр тогтмол хийж байх хэрэгтэй.

Бүрэлдэ хү үн	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байршил	Хугацаа ба давтамж	Нэгжийн өртөг, мян.төг	Нийт зардал мян.төг жил	Баримтлах стандарт ба арга аргачлал
Агаарын чанар	Температур, Агаарын урсгал, Чийгшил, Нүүрстөрөгчийн исэл, Хүхэрт устөрөгч, Метан, Азотын давхар исэл, Аммиак г.м	Уурхайн карьер Хөрсний овоолго Ажилчдын тосгон	Жил бүр 2 удаа. Шаардлагатай тохиолдолд тухай бүрд	24 цагийн хэмжилт хийж (O ₂ , SO ₂ , NO ₂ , CO , цаг агаарын үзүүлэлт)-ийг хамт тооцоход 100.0 мян.төг	500,0	MNS3113:1981. Агаар мандлын бохирдлыг хэмжих аргачлалын ерөнхий шаардлага , MNS0017-2-3-16:1988. Агаар мандал-Хот, суурингийн агаарын бохирдлын шинжилгээ MNS3384:1982. Агаар мандал- Агаарын дээжилт шинжилгээ MNS3113:1981. Хорт утааны ялгаралтыг хэмжих арга MNS5061:2001. Нүүрс хүчлийн хий- CO ₂ тодорхойлох эзэлхүүний арга

Хөрсөн бүрхэвч	Хөрсний үе давхаргын зузаан (см), элэгдэл эвдрэлийн нөхцөл, ялзмаг %, рН, давсжилт, чийгшилт, Pb, As, Cd, Hg, Cu – ийн агууламж Физик шинж чанар, органик бодис, нийт азот, карбонат, Ca, Mg, P ₂ O ₅ , K ₂ O, хөрсний	Харьцангуй эрүүл хөндөгдөөгүй газар Уурхайн карьер Хөрсний овоолго Ажилчдын тосгон	Жилд 2 удаа, 4 цэг дээр	Хөрсний механик бүрэлдэхүүн, ялзмаг 20.0 мян.төг Хөрсний хүнд металл шинжилгээний үнэ 45.0 мян.төг <u>*Газарзүйн хүрээлэнгийн үнэ</u>	520.0		MNS3985-87 Хөрсний ариун цэврийн байдлын үзүүлэлтийн нэр, төрөл MNS3310-91 Хөрсний агро химийн үзүүлэлтийг тодорхойлох MNS2305-94 Дээж авах, савлах, тээвэрлэх, хадгалах журам , MNS(ISO)4814:1999. Атом Шингээлтийн Спектрометрээр шинжилгээ хийлгэх
----------------	---	--	-------------------------	---	-------	--	---

	рН, Pb, Cd, As, Zn, Се –ийн агууламж			<i>авав.</i>							
	Усны рН, цахилгаан										
	дамжуулах чадвар										
	нүүрстөрөгчийн исэл										
	СО ₂ , хүчил НСО ₃ ,	Уурхайн ундны усны эх үүсвэрээс /гүний худаг/	Улиралд 1 удаа мониторингийн	Усны ерөнхий химийн шинжилгээ 46.0 мян.төг Усны 23 элемент хүнд металлын шинжилгээ 63.0 мян.төг Хими бактериологийн бүрэн шинжилгээний үнэ 141.7 мян.төг *	480.0 мян.төг		MNS0900:2005 Ундны ус-Ундны усны хяналт шинжилгээ MNS3935:1986 Ундны ус-Усны шинжилгээнд тавигдах шаардлага MNS3936:1986 Ундны ус болон үйлдвэрийн ус-Тухайн талбарт нь шинжилгээ хийх MNS4432:1997 Ундны ус-Хуурай үлдэгдлийн хэмжээг тодорхойлох MNS3934:1986 Ундны болон үйлдвэрийн ус-Химийн шинжилгээ хийх-дээж авах, хадгалах, зөөвөрлөх MNS5667-10:2001 Усны чанар-Дээж авах-2-р бүлэг. Хаягдал уснаас дээж авах MNS5667-2:2001 Усны чанар-Дээж авах-2-р бүлэг Дээж авах арга				
	кальци Са, хлор Сl,							цэгээс дээжлэлт хийж лабораторийн шинжилгээнд өгнө.			
	кали К, магни Mg, сод							Бактериологийн бүрэн шинжилгээ, хүнд металлын шинжилгээг жилд 1 удаа хийнэ.			
	Na, хүхэр S, хүнцэл										
	As, бор В, бари Ва,										
	Усан орчин кадми Cd, кобальт Со, хром Сг, зэс Сu, төмөр										
	Fe, мөнгөн ус Hg,										
	манган Mn, молибден										
	Mo, никель Ni, хар										
	тугалга Pb, селени Se,										

	Силикон Si, ванади V, Zn, Al, Ag,						MNS4867:1999 Усны чанар-Дээж авах-3-р бүлэг Авсан дээжийг зөөвөрлөх, хадгалах арга
	Хими бактериологийн бүрэн шинжилгээ						
Ургамал	Хээрийн судалгаа, суурин судалгаа	Үйлдвэр орчмын ургамлын бүрхэц, зүйлийн бүрдлийн судалгаа	Жилд 1 удаа		500.0		Мэргэжлийн байгууллага, мэргэжилтнээр хийлгэнэ.
Амьтан	Хээрийн судалгаа, тухайн орон нутагт хэрэгжиж буй амьтан хамгаалах арга хэмжээнд оролцох	Төсөл хэрэгжих талбай орчмын амьтны аймаг	Жилд 1 удаа		500.0		Мэргэжлийн байгууллага, мэргэжилтнээр хийлгэнэ
Ажиллагсдын эрүүл мэндийн хяналт үнэлгээ	Мэргэжлийн эрүүл мэндийн төвтэй гэрээ байгуулж ажиллана.		Жил бүр	Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн хөтөлбөрт тусгагдсан.	Үйл ажиллагааны зардалд		Ажлын байрны нөхцөл, эрүүл ахуй, хөдөлмөрийн нөхцөл болон аюулгүй ажиллагааны талаар баримталдаг Монгол улсын стандартууд
Нийт					2500.0		

Хүснэгт 22 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нэгдсэн төсөв

Д.д	Зардлын утга	2023 оны зардал мян.төг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний ажлын зардал	2400.0
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний зардал	<u>Хаалт, нөхөн сэргээлтийн зардалд тусгагдсан</u>
3	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах ажлын зардал	2400.0
4	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	1800.0
5	Эрсдлийн менежментийн төлөвлөгөөний зардал	2100.0
6	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардал	2500.0
7	Түүх соёл шинжлэх ухааны дурсгалт зүйлд зарцуулах болзошгүй зардал	500.0
Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардлын дүн		11700.0

“Мига эрин зуун” ХХК нь Байгаль орчны менежментийн 2023 оны төлөвлөгөөнд **11.7** сая/төг зарцуулахаар төлөвлөлөө. Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөг “Өндөр жавхлант” хүрэн нүүрсний ордын ТЭЗҮ, БОНБУ, 2023 оны уулын ажлын төлөвлөгөөнд үндэслэн боловсрууллаа. Бид уг байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, стандартын дагуу гүйцэтгэх болно.